

санд нэвтэрч үйл ажиллагаандаа ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх

-Өнөөгийн ШГГ-ын тогтолцоо, ШГА-г явуулж буй үйл ажиллагаа нь бодит байдлаас харахад хуулийн дагуу хараат бус явагдаж байгаа эсэхэд зарим талдаа учир дутагдалтай байна.



Ю.ОТГОНЖАРГАЛ

Сүхбаатар дүүргийн
157-р тойргийн
шийдвэр гүйцэтгэгч

**Г
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС
ТӨЛБӨР ГАРГУУЛАХ
АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ**

Шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн хуулиудыг батлан гаргасан билээ.

МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хууль нь өмнө дагаж мөрдөж байсан хуулиудаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар илүү нарийвчилсан хэдий ч хуулийг хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагаас төлбөр гаргуулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд зарим нэг хүндрэл тулгарч байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байгаа хүний хувьд энэ чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийж өөрийн хувь нэмрээ оруулах үүднээс уг сэдвийг сонгон авч судаллаа.

Энэхүү илтгэлийн хүрээнд төрийн байгууллагаас төлбөр гаргуулах ажиллагааны ойлголт, онцлог, түүний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг онол, практикын талаас нь

харьцуулан судалж санал, дүгнэлтээ гаргахыг зорилоо.

Төр иргэн хоёр харилцан эрх эдэлж, үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан өнөө үед төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлага өндөрсөж, иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалж буй нэг илрэл нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт¹⁵³ ...“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...эрхтэй. Мөн хуулийн 19-р зүйлийн 1 дэх хэсэгт ... “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан нь төрийн байгууллагаас төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөгөөтэйгүүр хохирлын сангийн хуулийг бий болгох үндэслэл болсон. Тусгай сангийн тухай хуулийн төслийг 2008 онд боловсруулан 12 төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санг тусгайлан байгуулж, журмыг Монгол Улсын Засгийн газар баталсан.

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн өр төлбөрийг төрөөс барагдуулсан тохиолдолд хяналт, төрийн байгууллагуудын уялдаа холбоогүйгээс гэм буруутай этгээд хариуцлагаас

зайлсхийх боломж олгож, дахин өр төлбөр үүсгэх нөхцлийг бүрдүүлдэг. Мөн засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213-р зүйлд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн эх үүсвэрийг шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60%-тай тэнцэх хөрөнгө гэж заасан боловч бүхэлдээ энэ хөрөнгө орон нутгийн төсөвт төвлөрч, багахан хэсэг Засгийн газрын тусгай санд орж байдаг.

Тиймээс энэхүү хохирлын сангийн эх үүсвэрээс төвлөрсөн мөнгөн хөрөнгийг шүүхээс шийдвэрлэсэн гэмт хэргийн хохирол төлбөрийг барагдуулахаар тусгасан. Монгол Улсын Шүүх засаглалын нэг томоохон хэсэг болсон Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлагыг хэрэгжүүлэх зорилт зүй ёсоор тавигдаж байна.

Төрийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас иргэнд хохирол учруулсан тохиолдолд хохирлын сангаас хохирлыг төлөхөөр заасан. Төсвийн байгууллагууд хохирол барагдуулахад зориулсан хөрөнгийг төсөвт суулгаж тусгайлан олгодоггүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ихээхэн хүндрэл гарсаар ирсэн. Дээрх асуудалтай холбоотойгоор төрийн байгууллагаас төлбөр гаргуулах болон хохирлыг барагдуулахад одоогийн нийгэмд гарч буй хэргийн нөхцөлүүдэд тулгуурлан төрийн байгууллагаас гэмт хэргийн хохирлыг

¹⁵³ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны №01-т хэвлэгдсэн.

хэрхэн барагдуулж байгаа болон төсвийн байгууллагад хохирол барагдуулахад зориулан хөрөнгө тусгайлан төсөвлөн олгодоггүйгээс төсөвт байгууллагаас төлбөр барагдуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 2009 он хүртэл зогсонги байдалд орж шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учирсны улмаас Хууль зүйн сайдын тухайн жилийн багцад тусгаж эхэлсэн ч төсөвт байгууллагаас гаргуулах төлбөр өнөөдрийн байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Гэвч төсөвт байгууллагаас гаргуулах 29.0 тэрбум төгрөгийн төлбөр өнөөдрийн байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол барагдуулах ажлын хүрээнд Хууль зүйн сайдын 2014 оны төсөвт 6.2 тэрбум төгрөг тусгуулах арга хэмжээ авч, уг мөнгөн хөрөнгийг Хууль зүйн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/50 дугаар тушаалаар 34 төлбөр авагчид 404.9 сая төгрөг, мөн 2014 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 8 төлбөр авагчид 5.8 тэрбум төгрөгийг олгохоор шийдвэрлүүлж, төлбөрийн мөнгө шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас иргэнд учруулсан хохирлыг барагдуулах ажлын хүрээнд Засгийн газрын нөөц сангаас гаргуулах 16 гүйцэтгэх баримт бичгийг Засгийн газрын тусгай сангийн хуульд заасны дагуу шийдвэрлүүлсэн байна.

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудлаар Комиссын зөвлөмж гарснаас хойш Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдөр Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль, 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийг тус тус баталжээ. Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд хадгаламж, зээлийн зарим хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж төлөгдөх нөхцөлөөр барагдуулах асуудлыг хуульчилсан. Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн хүрээнд Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудалд гарсан нэг гол ололт бол Улсын Их Хурлаас 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” бий болгожээ. Уг хуульд заасны дагуу энэхүү сангаас 2011 оноос хойш тус улсын нутаг дэвсгэрт хүч хэрэглэн, санаатай үйлдсэн, Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2-т заасан (Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах), 91 дүгээр зүйлийн 91.1, 91.2-т заасан (Хүнийг санаатай алах), 96 дугаар зүйлийн 96.1, 96.2-т заасан (Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах), 108 дугаар зүйлийн 108.3-т заасан (Хүн хулгайлах), 190 дүгээр зүйлийн 190.3-т заасан (Хүнийг хууль бусаар хорих), 112 дугаар зүйлийн 112.3-т заасан (Хүнийг

барьцаалах), 113 дугаар зүйлийн 113.3-т заасан (Хүн худалдаалах), 126 дугаар зүйлийн 126.2, 126.3 -т заасан (Хүчиндэх), 147 дугаар зүйлийн 147.3-т заасан (Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх), 177 дугаар зүйлийн 177.2-т заасан (Зандалчлах), 178 дугаар зүйлийн 178.1.2 -т заасан (Терроризм), 251 дугаар зүйлийн 251.2, 251.3 -т заасан (Эрүү шүүлт тулгах) гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хохирогчийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид төрөөс шүүхийн шийдвэрийг үндэслэн тодорхой хэмжээний нөхөн төлбөр олгохоор тусгажээ.

ХЗҮХ-ээс явуулсан “Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал”¹⁵⁴ сэдэвт ажил байх бөгөөд энэ судалгаагаар төрийн хариуцлагыг тусгасан иргэний ба захиргааны эрх зүйн зохицуулалтууд практикт хэрэглэгдэхгүй байгааг тогтоогоод бие даасан хууль батлах нь зүйтэй гэсэн санал дүгнэлтэд хүрсэн байдаг. Харин төрийн хариуцлагын эрх зүйн ерөнхий зохицуулалтыг Үндсэн Хуулийн зарчимтай уялдуулах, төрийн хариуцлагын механизмыг нэг цогц болгон хууль хэрэглэгчдэд хүргэх, ганцхан албан тушаалтны учруулсан гэм хорыг судлах бус, бусад зохицуулалттай холбон судалж, нэгдсэн системтэй ойлголтод хүрэх зорилгоор цогц судалгаа хийх шаардлага байсаар байна. Хэдийгээр Үндсэн Хуульд төрийн хариуцлагын эрх зүй хөгжих ёстойг тусгасан агуулга бүхий

зохицуулалт олон боловч эрх нь зөрчигдсөн иргэний хохирлоо арилгуулах шаардах эрх нь яг ямар зохицуулалт байхыг тодорхойлох, судлах шаардлагатай.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны улмаас учирсан хохирол, үр дагаврыг арилгуулах арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь энэ төрлийн хууль тогтоомжийг бий болгоод зогсохгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ бусад эрхийн зохицуулалттай уялдуулах нь чухал юм.

¹⁵⁴ ХЗҮХ: Судалгааны тайлангийн эмхэтгэл, I дэвтэр, 294- 327 дахь тал.